

**БАТЛАВ: “ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН ТӨВ” ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

  
**М.ЭНХСАЙХАН**  
**ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРЛАЛ**

“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоонд аудит хийх, баталгаажуулах, сургалт зохион байгуулах ажлыг хэрэгжүүлэх зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

**1. ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО:**

- 1.1 Монгол улсын Кибер аюулгүй байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 207 тоот тогтоолыг үндэслэн “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн Мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоо, стандартын хэрэгжилтэд аудит хийж баталгаажуулах.
- 1.2 “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн Мэдээллийн аюулгүй байдлын бодлого, үйл ажиллагаа, журам, стандартад үзлэг ажиглалт явуулах, ярилцлага хийх.
- 1.3 Програм хангамж, өгөгдлийн сан, мэдээлэл солилцох эрсдэлийн үнэлгээ хийх.
- 1.4 Техник хангамж, сүлжээ, орчны үнэлгээ, цахим шуудангийн аюулгүй байдлын эрсдэлд үнэлгээ хийх.
- 1.5 Аудитаар илэрсэн асуудлыг арилгах зөвлөмжийг багтаасан аудитын дүгнэлт боловсруулж ирүүлэх;

**2. МЭДҮҮЛЭГ ИРҮҮЛЖ БУЙ ЗӨВЛӨХ НЬ УГ ҮЙЛЧИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭХ  
ЧАДВАРЫГ НОТЛОХ БАРИМТ:**

- 2.1 Тухайн байгууллага үйл ажиллагаа явуулаад 5-с доошгүй жил ажилласан байх, сүүлийн 5 жилд үйлчилгээ үзүүлсэн компаниудын нэрс, хийж гүйцэтгэсэн ажлын товч танилцуулга, сүүлийн 1 жилд 2 төрийн байгууллагад мэдээллийн аюулгүй байдлын аудит, эрсдэлийн үнэлгээ хийсэн байх.
- 2.2 Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийсэн компанитай байгуулсан гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн актын хуулбар.
- 2.3 Ажилтнуудын анкет, мэргэжлийн дипломын хуулбар, аудит хийх эрхийн гэрчилгээний хуулбар.
- 2.4 Аудит хийх мэргэжлийн багтай байх, багын ахлагч Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын Зөвлөх инженер байх, орон тооны аудитор нь CISA, CISM, CISSP-ийн аль нэг хүчин төгөлдөр гэрчилгээтэй байх. (гэрчилгээнүүдийн дугаарыг гэрчилгээ олгосон байгууллагын албан ёсны веб хуудаснаас шалгана)
- 2.5 Гэрчилгээ бүхий ажилтан нь гүйцэтгэгч компанид 2 жил ажилласан байх.

### 3. ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ ҮНДСЭН ШААРДЛАГУУД:

- 3.1 Монгол Улсын кибер аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 заалт болон бусад холбогдох заалтууд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/74 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журам”-ын шаардлагуудыг тус тус хангасан байх.
- 3.2 Мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоо, үйл ажиллагаанд аудит хийх эрхтэй байх.
- 3.3 Тус тендерт оролцох тухай албан хүсэлтэд дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:
  1. Байгууллагын ерөнхий танилцуулга.
  2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар.
  3. НӨАТ-ын гэрчилгээний хуулбар.
  4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт.
  5. Нийгмийн даатгалын болон татварын тодорхойлолт (өргүй байх)
  6. Сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан /2021, 2022, 2023 он/

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2024.05.09-2024.05.28-ны өдрийн хооронд ажлын цагаар /08:30-17:30/ цагт авч болох бөгөөд мэдүүлгээ [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар 2024.05.29-ний өдрийн 10:00 цагийн дотор ирүүлнэ үү.

Хүлээн авагчийн нэр: **ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН ТӨВ**

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Ж.Самбуугийн гудамж-16/1, “ҮЦТХТ” ХХК-ийн байр.

Утасны дугаар: 70120460, 99065737

Цахим шуудангийн хаяг: [info@mcsd.mn](mailto:info@mcsd.mn), [byambazaya@mcsd.mn](mailto:byambazaya@mcsd.mn)